



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Г Г
Г

Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүний брокерын гишүүнээр элсүүлсүгэй.
2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай "Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ" байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг "Инвескор Капитал ҮЦК" ХХК (Л.Билгүүн)-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын бэк оффис (back office)-ын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж 2024 оны 03 сарын 30 өдрөөс өмнө дуусгахыг "Инвескор Капитал ҮЦК" ХХК (Л.Билгүүн)-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Цогтбаяр/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010025